



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН- ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

Эрүүл мэндийн газрын 2016, 2017 оны үйл ажиллагааны үр дүн

**Эрүүл мэнд, спортын яамнаас баталсан орон тооны
хязгаараас хэтрүүлж, орон тоогоо баталж ажилласан
байна.**

Баян-Өлгий аймаг, Өлгий сум

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

**Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын
газар**

Дарга, Тэргүүлэх аудитор
М.Хуанган

Аудитын менежер
Х.Женисбек

Аудитын баг
Ахлах аудитор
Д.Назгүл

Аудитор
Р.Баярмаа

2018 оны 6 дугаар сар

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70422954, 70422930, 70423073 дугаарын утсаар хандана уу.

Хаяг: Аймгийн ЗДТГазрын байр 1-давхар

ХАЯГ: Аймгийн ЗДТГазрын байр, 1 дүгээр давхар 110, 112 тоот өрөө

Товчилсон үгийн тайлбар3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй4

Бүлэг 1 Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлсэн эсэх талаар.

1.1 Эрүүл мэндийн газрын бүтэц орон тооны төлөвлөлтийн талаар5-8

1.2 2016, 2017 оны төлөвлөгөөт үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан эсэх талаар8-13

1.3 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан эсэх талаар13-16

1.4 Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх талаар16-17

1.4 Төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтын талаар17

Бүлэг 2 Эрүүл мэндийн салбарын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнтэй хэрэгжсэн эсэх талаар.

2.1 Төсөл хөтөлбөрийн төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн эсэх талаар18-19

2.2 Төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулсан эсэх талаар19-20

2.3 Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт хангалттай хэрэгжсэн эсэх талаар20-21

Бүлэг 3 Худалдан авах ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх талаар.

3.1 Худалдан авах ажиллагааг хэрэгцээ, шаардлагад үндэслэн үр ашигтай төлөвлөсөн эсэх талаар22-23

3.2 Худалдан авах ажиллагааг үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлсэн эсэх талаар23-25

Дүгнэлт26

Зөвлөмж27

Байгууллагын санал28

Баталгаажуулсан гарын үсэг29

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт:

Монгол Улсын Ерөнхий аудиторт 2018 онд нийлүүлэх ажил үйлчилгээний төлөвлөгөө, аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Эрүүл мэндийн газрын 2016, 2017 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж үр дүнг холбогдох байгууллагад танилцуулах, үйл ажиллагааны үр дүнг сайжруулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтнуудад санал, зөвлөмж өгөх, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Хамрах хүрээ:

Энэхүү аудитад Эрүүл мэндийн газрын 2016, 2017 оны үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан, санхүүгийн баримт материал, ажлын төлөвлөгөө, тооцоо судалгаа бусад холбогдох баримтуудыг хамруулав.

Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материалд үндэслэн хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, ажлын тайлан, баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг ахлах аудитор Д.Назгүл ахалж, аудитор Р.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг 2018 оны 05 дугаар сарын 10-аас эхлэн 06 дугаар сарын 30-ны хооронд хийж гүйцэтгэв.

Бүлэг 1

**Батлагдсан орон тооны хязгаарыг хэтрүүлж
ажилласан байна.**

Оршил

Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газар, Эрүүл мэндийн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан бодлого, шийдвэрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, зохицуулах, хэрэгжилтийг хянах, харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага байна.

Аймгийн хэмжээнд ЭМГ-ын харьяа 21 төсвийн байгууллага, 44 хувийн хэвшлийн аж ахуйн нэгж бүгд 65 байгууллага эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж, энэ салбарт нийт 1257 хүн ажилладаг байна.

Аймгийн Эрүүл мэндийн газар нь байгууллагын www.health.bo.gov.mn цахим хуудас ажиллуулж, мэдээллээ тогтмол байршуулж ажилласан байна. Улирал тутам аймгийн эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлтүүдээр мэдээлэл бэлтгэн, сар бүрийн мэдээний гол үзүүлэлтүүдээр өмнөх жилийн мөн үетэй харьцуулсан байдлаар шийдвэр гаргах түвшний хүмүүст мэдээлж ажиллажээ.

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн салбар байгууллагуудын 2016 оны ажлын үнэлгээгээр улсад 5 байранд шалгарч, 2016 оны тайланг аймгийн удирдлагуудад тайлагнаж 92,3 хувиар “хангалттай сайн” үнэлгээ авчээ.

2017 онд ажлын тайлангаа аймгийн Засаг даргад тайлагнаж 75 хувиар үнэлгээ авсан байна.

1. Батлагдсан орон тооны хязгаарыг хэтрүүлж ажилласан байна.

1.1. Эрүүл мэнд, спортын яамнаас баталсан орон тооны хязгаараас хэтрүүлж орон тоогоо баталж ажилласан байна.

Эрүүл мэндийн яамнаас хянаж ирүүлсэн тус газрын 2016, 2017 оны төсөвт орон тооны хязгаарыг 39-ээр баталсан байна.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг батлах тухай” 415 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан үлгэрчилсэн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэлийн дагуу өөрийн аймгийн Засаг даргатай зөвшилцөн эрүүл мэндийн газрын бүтцээ батлуулж ажиллахыг үүрэг болгосон байна.

Эрүүл мэндийн сайдын 415 дугаар тушаалыг үндэслэн аймгийн Засаг даргын 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/202 тоот захирамжаар аймгийн Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тооны хязгаарыг 63-аар баталжээ.

Сайдын тушаал, аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэн Эрүүл мэндийн газрын даргын “Орон тоог шинэчлэн тогтоож, ажил, албан тушаалын жагсаалт батлах тухай” 2016 оны 3 дугаар сарын 15-ны А/06 тоот тушаалаар Эрүүл мэндийн газрын орон тоог 48-аар тогтоож, ажил, албан тушаалын жагсаалтыг 1 дүгээр, орон тоо цалингийн санг 2 дугаар хавсралтаар шинэчлэн баталсан байна.

Баталсан ажил, албан тушаалын жагсаалтаар Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс 18, Эмнэлгийн тусламжийн хэлтэс 6, Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтэс 14, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс 5, гэрээт ажилтан 1 буюу нийт 47 орон тоотой байна.

Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 30-ны А/04 тоот тушаалаар 2017 онд мөрдөх орон тоо, цалинг баталсан байна. 2017 онд Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс 19, эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс 6, Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтэс 7, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс 5, гэрээт ажилтан 11 бүгд 48 ажилтан, албан хаагчийн цалинг баталжээ.

Өмнөх оны цалин тогтоолтоор батлагдсан орон тооноос 1 орон тоо илүү байгаа шалтгаан нь 2016 оны 6 дугаар сард газрын НЭМТөвийн сүрье, БЗДХ-ын тандалт сэргийлэлт хариуцсан орон тоог нэмэгдүүлж ажиллуулж байсныг 2017 онд орон тоог нэмж баталсантай холбоотой байна.

Эрүүл мэндийн яамнаас баталсан орон тооны хязгаараас 2016, 2017 онуудад 8-9 орон тоог илүү ажиллуулж Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.2-т “батлагдсан төсвийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчиж ажилласан байна.

Эрүүл мэндийн газрын даргын 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Б/30 тоот тушаалаар аймгийн Засаг даргын “Аймгийн Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоог батлах тухай” 2015 оны А/202 дугаар захирамжийг үндэслэн хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулан өмгөөлөгч Х.Бакенийг орон тооны хуулийн зөвлөхөөр авч ажиллуулсан байна.

Эрүүл мэндийн сайдын “Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг батлах тухай” 415 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар Эрүүл мэндийн газрын бүтэц орон тоо, үйл ажиллагааны үлгэрчилсэн чиглэлийг баталжээ. Энэхүү чиглэлд Эрүүл мэндийн газрын Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлд “хууль эрх зүйн зөвлөгөө” гэж орсныг үндэслэж аймгийн Засаг даргын захирамжаар газрын бүтэц орон тоог батлуулахдаа Хууль эрх зүйн зөвлөгөө-1 гэж баталсныг үндэслэн хуулийн зөвлөх гэсэн орон тоог байгууллагын бүтэц орон тоонд оруулж тушаалаар баталсан байна.

Аймгийн Засаг даргын “Аймгийн Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоог батлах тухай” 2015 оны А/202 дугаар захирамж, Эрүүл мэндийн газрын даргын 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн Б/30 тоот тушаалыг үндэслэн өмгөөлөгч Х.Бакенийг орон тооны хуулийн зөвлөхөөр авч ажиллуулсан гэх боловч тус газарт ажиллаагүй, ажлын байрны тодорхойлолтгүй, ажилласан тухай цагийн бүртгэл байхгүй, хуулийн туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулан сар бүр цалингийн сангаас 400,0 мянган төгрөгийн хөлс олгож, НДШимтгэл төлж ирсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ”, 11.2-т “энэ хуулийн 5.1.2, 5.1.3-т заасан албан тушаалын ангиллын хүрээнд төрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалыг мэргэшлийн үндсэн дээр байнга эрхэлж байгаа Монгол Улсын иргэнийг төрийн жинхэнэ албан хаагч гэнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Эрүүл мэндийн газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар орон тооны хязгаарыг 8 хүнээр хэтрүүлэн ажиллуулж байгаа зөрчлийг арилгаж, зохион байгуулалтын арга хэмжээ авах, цаашид орон тооны хязгаарыг мөрдөж ажиллах талаар албан шаардлага өгөгдсөн.

Албан шаардлагын биелэлтийг Эрүүл мэндийн газрын даргын 2018 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 496 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Албан шаардлагын дагуу 2018 оны 02 дугаар сард Эрүүл мэндийн газраас 3 ажилтныг чөлөөлж, аймгийн Нэгдсэн эмнэлэгт шилжүүлж, үлдсэн илүү орон тоог Эрүүл мэндийн яаманд асуудал тавьж ажиллаж байгааг дурдсан байна.

Хуулийн зөвлөх Х.Бакенийг 2018 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон хуулийн зөвлөхийн ажлаас чөлөөлж байгуулсан гэрээг дуусгавар болгох, хуулийн зөвлөх авч ажиллуулах шаардлагатай бол зохих хууль журмын дагуу авч ажиллуулан ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг баталж, ажлын байр, тухайн газар байнга сууж ажиллах нөхцөл бололцоогоор хангах арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага өгөгдлөө.

1.2 2016, 2017 оны төлөвлөгөөт үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Эрүүл мэндийн газар нь 2016 онд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.Үүнд:

1. Хүний нөөцийн бодлогыг хөгжүүлэх, тасралтгүй хэрэгжүүлэн ажиллах зорилтын хүрээнд 6,

2. Аймгийн хүн амыг эм, эмнэлгийн хэрэгслээр жигд хүртээмжтэй хангах, зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг нэмэгдүүлэх, эмийн аюулгүй байдал, чанарт хяналт тавих зорилтын хүрээнд 3,

3.Эх хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх эмнэлгийн тусламжийг сайжруулах зорилтын хүрээнд 35,

4. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр гарсан бодлого, хууль тогтоомж, дүрэм, стандартыг мөрдөн хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг өрнүүлэх,

байгууллага хамт олны оролцоог нэмэгдүүлж хамтран ажиллах зорилтын хүрээнд 45,

5.Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэхийн тулд байгууллагын удирдлага, зохион байгуулалт, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, үр дүнд үнэлгээ хийж, хэрэглэгчдийг нотолгоонд тулгуурласан мэдээлэл, хяналт-шинжилгээний дүгнэлт, зөвлөмжөөр хангах зорилтын хүрээнд 10 ажлыг тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлийг ханган ажиллаж биелэлтийг тооцсон байна.

Эрүүл мэндийн газар нь 2017 онд “Үйлчлүүлэгчид, өрх, гэр бүлийн эрхийг дээдэлсэн, эрэлт, хэрэгцээг хангасан, тэгш хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлснээр эрүүл урт насалж, амьдралын чанарыг дээшлүүлэх” үндсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилт, үр дүнг тооцож, үйл ажиллагаагаа тайлагнаж ажилласан байна.

ЭМЯ-аас 2017 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгож зарласантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/96 дугаар захирамжаар “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих, харилцаа, хариуцлагыг дээшлүүлэх жил” болгож 28 төрлийн ажил төлөвлөж, зохион байгуулсан байна.

-Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр гарсан бодлого, хууль тогтоомж, дүрэм, стандартыг мөрдөн хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг өрнүүлэх, байгууллага хамт олны оролцоог нэмэгдүүлж хамтран ажиллах зорилтын үр дүнд: олон нийтэд чиглэсэн 2011 сургалт, сурталчилгаа явуулж, ба давхардсан тоогоор 106117 хүн хамрагдаж, халдварт өвчний тоо өмнөх оноос 1,8 дахин буурч, товлот, дархлаажуулалтын хамралт 98,1% -т хүрчээ.

-Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулах зорилтын үр дүнд: нярайн эндэгдэл өмнөх оноос 20 тохиолдлоор буурч 15, эхийн хүндрэлийн өмнөх оноос 14 тохиолдлоор буурч 3 тохиолдол гарч, 0-1 насны хүүхдийн эндэгдэл өмнөх онд 14,5 байсан нь 13,5 болж, 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өмнөх онд 32,1 байсан нь 17,9 болж буурч, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 80,3% нь сэтгэл ханамжтай гэж дүгнэсэн.

-Аймгийн хүн амыг эм, эмнэлгийн хэрэгслээр жигд хүртээмжтэй хангах, зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг нэмэгдүүлэх, эмийн аюулгүй байдал, чанарт хяналт тавих зорилтын үр дүн: эмийн хангалттай холбоотой асуудал гараагүй, эмийн сангуудын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, эмийн сангийн бүтэц, үйл ажиллагааны стандартын мөрдөлт сайжирч, эмийн зохистой хэрэглээний талаарх ургалт сурталчилгааг эрчимжүүлж иргэдийн эрүүл мэндийн боловсрол тодорхой хэмжээгээр нэмэгдсэн байна.

-Хүний нөөцийн бодлогыг хөгжүүлэх, тасралтгүй хэрэгжүүлэн ажиллах, нийгмийн баталгааг хангах зорилтын үр дүн: нарийн мэргэжлийн эмчийн тоо өмнөх оноос 14-өөр нэмэгдэж, эмч нарын 64 хувийг нарийн мэргэжлийн эмч, ажилчдын 7,3%-ийг мэргэжлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид эзлэх болсон байна.

-Байгууллагын удирдлага, төлөвлөлтийг боловсронгуй болгох, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилтын үр дүн: Эрүүл мэндийн салбарт 2016 онд 1221,6 сая төгрөгийн, 2017 онд 1283,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, иргэдийн өргөдөл, гомдлын 97 хувийг шийдвэрлэж, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг ймагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр буюу салбарын дунд хугацааны стратеги төлөвлөгөө батлагджээ.

-Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэхийн тулд байгууллагын удирдлага, зохион байгуулалт, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, үр дүнд үнэлгээ хийж, хэрэглэгчдийг нотолгоонд тулгуурласан мэдээллээр хангах зорилтын үр дүнд: жил бүр 3-4 сумын эрүүл мэндийн төвд зөвлөн туслах баг ажиллаж, хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласнаар тусламж, үйлчилгээний чанар хүртээмж тодорхой түвшинд сайжирч, ЭМГ-ын цахим хуудсыг шинэчилж хийгдэж буй томоохон үйл ажиллагаанууд, бусад мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг, гарын авлагыг байршуулж, ард иргэдийг мэдээллээр хангаж, телемедиагийн сүлжээг ашигласнаар эдийн засгийн хэмнэлт хийгдэж, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд мэдээ, мэдээллээр тогтмол хангагдаж, Улаанбаатар хот болон бусад аймгуудын эрүүл мэндийн байгууллагуудтай мэдээлэл солилцож, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх боломж бүрдсэн байна.

1.3 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2016 онд ЭМГ 1694,1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж гүйцэтгэлээр 1674,5 сая төгрөгийг зарцуулж, 19,6 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

2016 онд аймгийн Засаг даргын захирамжаар 17,4 сая төгрөгийн, Эрүүл мэндийн яам, ХӨСҮТөв болон бусад газраас 18,3 сая төгрөгийн, хандив тусламжаар 9,4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зарцуулжээ.

ЭМЯ-аас 0,2 сая төгрөгийн бараа материал, Дэлхийн зөн олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар 3,9 сая төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна.

2017 онд 1905,3 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1788,2 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаандаа 1753,6 сая төгрөгийг зарцуулж, 34,6 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

2017 онд нэмэлт санхүүжилтээр НҮБ-ын Хүн амын сангаас эх баригчдын мэргэжил дээшлүүлэх сургалтын зардалд 3,9 сая төгрөгийн, Сүрьеетэй тэмцэх нийгэмлэгээс сүрьегийн сорьц тээвэрлэх зардалд 1,9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн яамны Эх хүүхдийг дэмжих сангаас НЭМ-ийн үйл ажиллагааны санхүүжилтэнд 40,2 сая төгрөгийн, Орон нутгийн төсвөөс Онцгой байдлын гамшгийн үзлэг сургалтын зардалд 6,1 сая төгрөгийн, НДСангаас ХЧТА болон ЖАТ-ийн зардалд 5,8 сая төгрөгийн буюу нийт дүнгээр 1846,3 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаандаа зарцуулжээ. Хөрөнгө оруулалтаар 30,8 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч бүртгэлд тусгажээ.

Эрүүл мэндийн газрын 2016 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй санал дүгнэлт” өгсөн байна.

2016, 2017 оны батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгаа
/Эх сурвалж: ЭМГ-ын 2016, 2017 оны санхүүгийн тайлангаас/

Хүснэгт №1

Сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 он			2017 он		
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл						
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,694.1	1,674.5	19.6	1,905.3	1,753.6	151.7
УРСГАЛ ЗАРДАЛ	1,694.1	1,674.5	19.6	1,905.3	1,753.6	151.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	493.7	490.1	03.6	505.2	500.2	05.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	360.2	360.2	00.0	365.6	365.5	00.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39.6	39.6	00.0	40.2	40.2	00.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35.6	35.6	00.0	40.1	35.5	04.6
Хангамж, бараа материалын зардал	15.6	15.6	00.0	16.8	16.8	00.0
Нормативт зардал	04.0	04.0	00.0	04.4	04.4	00.0
Эд хогшил, урсгал засварын зардал	06.1	04.1	02.0	05.6	05.6	00.0
Томилолт, зочны зардал	04.7	04.7	00.0	04.9	04.9	00.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10.8	10.8	00.0	10.7	10.4	00.3
Бараа үйлчилгээний бусад зардал	17.0	15.4	01.6	16.8	16.8	00.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,200.4	1,184.4	16.0	1,400.1	1,253.5	146.6
Бусад урсгал шилжүүлэг	1,200.4	1,184.4	16.0	1,400.1	1,253.5	146.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,015.9	999.9	16.0	662.1	551.4	110.7
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	184.5	184.5		704.2	688.5	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.0		00.0	33.7	13.8	19.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,694.1	1,674.5	19.6	1,788.2	1,753.6	34.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,694.1	1,674.5	19.6	1,788.2	1,753.6	34.6
Улсын төсвөөс санхүүжих	1,694.1	1,674.5	19.6	1,788.2	1,753.6	34.6

2016 онд нийт төсвийн 21,5 хувийг буюу 360,2 сая төгрөгийг цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд, 2,4 хувийг буюу 39,6 сая төгрөгийг НДШ-ийн зардалд, 59,7 хувийг буюу 999,9 сая төгрөгийг тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд, 11 хувийг буюу 184,5 сая төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардалд, 5,4 хувийг буюу 90,3 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардалд зарцуулжээ. /Хүснэгт №1-ээр харуулбал/

2016 онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардлыг 16,0 сая төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 2,0 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,6 сая төгрөгөөр буюу нийтдээ 19,6 сая төгрөгөөр хэмнэсэн дүнтэй байна.

2017 онд нийт төсвийн 20,8 хувийг буюу 365,5 сая төгрөгийг цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд, 2,3 хувийг буюу 40,2 сая төгрөгийг НДШ-ийн зардалд, 31,4 хувийг буюу 551,4 сая төгрөгийг тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд, 39,3 хувийг буюу 688,5 сая төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардалд, 6,2 хувийг буюу 108,0 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

2017 онд байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 4,6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний төлбөрийг 0,3 сая төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 110,7 сая төгрөгөөр, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардлыг 15,7 сая төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 19,9 сая төгрөгөөр тус тус хэмнэжээ./Хүснэгт №1-ээр харуулбал/

Аудитаар ажиллагсдын цалин хөлсний тооцоог шалгаж үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

-Эрүүл мэнд, спортын яамны сайдын 2016 оны 4 дүгээр сарын 13-ны 1а/1520 тоот албан тоотоор 2015 оны жилийн эцсийн санхүүгийн ажлын үр дүнгээр удирдах болон санхүүгийн ажилтнуудыг урамшуулах зөвшөөрөл ирүүлсэн ба газрын дарга санхүү бүртгэлийн ажилтнуудын ажлыг дүгнэж, хэдэн хувиар урамшуулах талаар тушаал гаргаж баталгаажуулаагүй байна.

-Эрүүл мэнд, спортын яамны 1а/1520 тоот албан тоотыг үндэслэж 2015 оны ажлын үр дүнгээр улирлын цалингийн 75 хувиар тооцож дарга С.Айгүлд 1849,0 мянган төгрөгийн, нягтлан бодогч Х.Ленад 1343,5 мянган төгрөгийн, эдийн засагч О.Айботаг 1316,8 мянган төгрөгийн нийтдээ 4509,3 мянган төгрөгийг балансын шагнал олгосон байна.

-Эрүүл мэнд, спортын сайдын 2017 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн А/243 тоот тушаалаар ажлын үр дүнгээр хангалттай үнэлгээ авсан байгууллагын дарга, санхүү бүртгэлийн ажилтнуудад төсөвтөө багтаан урамшуулал олгохыг зөвшөөрсөн боловч хэдэн хувиар урамшуулах талаар тусгаагүй байна. Үүнийг үндэслэн 2017 онд улирлын цалингийн 50 хувиар тооцож дарга С.Айгүлд 1232,7 мянган төгрөгийн, нягтлан бодогч Х.Ленад 940,8 мянган төгрөгийн балансын шагнал олгосон байна.

-Өөр ажил албан тушаал хавсран гүйцэтгэсний цалин хөлсийг хавсарсан ажил, албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас илүүгүй хэмжээгээр тогтоож олгох талаар холбогдох журмыг зөрчиж эдийн засагч О.Айбота жирэмсэн амаржсаны чөлөө авахад нягтлан бодогч Х.Ленагаар ажлыг нь хавсруулан 60 хувиар тооцож 1047,5 мянган төгрөгийн нэмэгдэл хөлсийг илүү олгосон байна. Энэхүү зөрчлийг арилгахыг албан шаардлагаар үүрэг болгов.

- ЭМГ-ын даргын тушаалаар баталсан амралтын хоног, амралтын мэдэгдэх хуудас зөрүүтэй байгаагаас 2016 онд 2 хүнд 231,6 мянган төгрөгийн, 2017 онд 1 хүнд 60,8 мянган төгрөгийн амралтын цалинг илүү тооцож олгосон зөрчилд акт тогтоов.

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга санхүү бүртгэлийн ажилтнуудын ажлыг дүгнэж, ямар хувь хэмжээгээр шагнаж урамшуулах талаар тушаалаар баталгаажуулж байх, газрын даргад балансын шагнал олгохдоо дээд шатны

төсвийн захирагчийн тушаал шийдвэрээр олгох, ажил хавсран гүйцэтгэсний хөлсийг хуульд заасан хувь хэмжээгээр тогтоож олгож байх, энэхүү зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөгдөж, илүү олгосон амралтын цалин 292,4 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Дээрх гарсан зөрчлүүд нь "Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн, 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Эрүүл мэндийн салбараас 2016 онд тэтгэвэрт гарах 41 албан хаагчид 636,1 сая төгрөгийн тэтгэмж олгох төлөвлөгөөтэй байснаас гүйцэтгэлээр 999,9 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна. Шалтгааныг тодруулахад: 2015 онд тэтгэвэр тогтоолгосон боловч тэтгэмжээ бүрэн гүйцэд аваагүй байсан 36 албан хаагчид 438,1 сая төгрөгийн, 2016 онд төлөвлөгөөнд орсон 34 албан хаагчид 511,8 сая төгрөгийн, төлөвлөгөөнд ороогүй боловч тэтгэврээ тогтоолгосон 4 албан хаагчид 50,0 сая төгрөгийн тэтгэмж олгожээ.

2017 онд тэтгэвэрт гарсан 32 хүнд 550,3 сая төгрөгийн, өмнөх онд тэтгэвэрт гарсан ажилтны тэтгэмжийн зөрүүд 1,1 сая төгрөгийн буюу нийт дүнгээр 551,4 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.

2016 онд Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй 55 албан хаагчид хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр эдгээр 55 албан хаагчид 184,5 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.

2017 онд аймгийн эрүүл мэндийн салбарт ажиллаж буй 213 албан хаагчид хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 704,2 сая төгрөгийн тэтгэмж олгохоор төлөвлөгдсөн ба гүйцэтгэлээр төлөвлөгөөнд тусгагдсан тэтгэмжээс 15 албан хаагчийн 51,4 сая төгрөгийн тэтгэмж олгогдоогүй ба төлөвлөгөөнд ороогүй байсан 11 албан хаагчид 35,7 сая төгрөгийн тэтгэмж олгогдсон байна.

Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж болон тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмжийн зардлаас олгогдоогүй үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

1.4 Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн Acolous программ ашиглаж хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргаж, цалингийн тооцоог Payroll программыг ашиглаж хийж, нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримтын бүртгэлийг зохих журмаар хөтөлж, өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлж ажилласан байна.

2016, 2017 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх комиссыг газрын даргын тушаалаар томилж, эд хөрөнгийг тооллогыг зохих журмын дагуу хийсэн байна.

2016 онд төсвийн хөрөнгөөр 10,6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авч, хөрөнгийн санхүүжилтээр 3,9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан байна. Төсвийн хөрөнгөөр 20,2 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч 16,9 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулж, оны эцэст 36,7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

2017 онд төсвийн хөрөнгөөр 8,9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, ном худалдан авч, хөрөнгийн санхүүжилтээр 30,7 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл хүлээн авч бүртгэлд тусгасан байна. Тайлант онд хөрөнгө шилжүүлж, актлаагүй байна. Төсвийн хөрөнгөөр 22,9 сая төгрөгийн бараа материалыг худалдан авсан ба үйл ажиллагаандаа 21,6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 0,9 сая төгрөгийн бараа материалыг акталж устгаж, оны эцэст 37,2 сая төгрөгийн бараа материалыг үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалыг зөв ангилан бүртгэж, үндсэн хөрөнгийн элэгдлийг зохих журмын дагуу тооцож байгуулсан байна.

1.5 Төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хариуцсан нэгж, ажилтан байхгүй байна.

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, төсвийн зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлэх дотоод хяналтыг хариуцсан нэгж, ажилтан байхгүй байна.

Санхүүгийн мэдээллийн самбар ажиллуулж батлагдсан төсөв, зарлага санхүүжилтийн мэдээ, аудитын байгууллагын санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт зэргийг байрлуулсан байна.

Тус газар нь хуулийн зөвлөхийн байнгын орон тоонд хууль бусаар цалин олгож, гэрээгээр хуулийн зөвлөгөө авахын оронд тус орон тоонд эрүүл мэндийн салбарын дотоод хяналт, хууль эрх зүй хариуцсан орон тооны мэргэжилтэн авч ажиллуулах нь зүйтэй байна.

Бүлэг 2

2016 оны төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 60,8 хувьтай, 2017 оны төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 77,4 хувьтай байна.

2. 2016 оны төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 60,8 хувьтай, 2017 оны төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 77,4 хувьтай байна.

2.1. Төрөөс хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

Эрүүл мэндийн газар нь чиг үүргийнхээ дагуу 2016, 2017 онуудад Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөрүүдийг аймаг орон нутагт хэрэгжүүлэх, хяналт тавих эрхээ хэрэгжүүлж ажилласан боловч үндэсний хөтөлбөрүүдийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулж, төлөвлөгөө батлуулж ажиллаагүй байна.

2016, 2017 онд хэрэгжиж байсан үндэсний хөтөлбөрүүд /Эх сурвалж:ЭМЯамны вэб сайт, ЭМГ-ын дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас/
Хүснэгт№2

№	Үндэсний хөтөлбөр	Үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа хөтөлбөрүүд				Хэрэгжилтийг ирүүлсэн		Дэд хөтөлбөр батлуулж ажилласан эсэх	
		Хэрэгжих үе шат	Хугацаа	2016 он	2017 он	2016 он	2017 он	2016 он	2017 он
1	Эрүүл насжилт, настны эрүүл мэнд	2	2014-2017, 2018-2020	+	+	+	+	-	-
2	Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр	2	2012-2016, 2017-2021	+		+		+	
3	Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний дөрөв дэх хөтөлбөр	4	1997-2016	+		+		-	
4	Үндэсний түргэн тусламжийн сүлжээ хөтөлбөр	2	2010-2013, 2014-2016	+		+		-	
5	Сэтгэцийн эрүүл мэнд үндэсний хоёр дахь хөтөлбөр	2	2010-2014, 2015-2019	+	+	+	+	-	-
6	Хотжилт ба эрүүл мэнд үндэсний хөтөлбөр	1	2016-2020	+	+	+	+	-	-
7	Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх	2	2010-2012, 2013-2016	+		+		-	
8	Эрүүл мэнд үндэсний хөтөлбөр	2	2010-2015, 2016-2021	+	+		+	-	-
9	Орчны эрүүл мэнд	1	2017-2020		+		+		-
10	Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр	2	2017-2019, 2020-2021		+		+		-
11	Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөр	1	2017-2020		+		+		-
12	Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд	1	2017-2021		+		+		-
13	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр	1	2017-2021		+		+		-
14	Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр	1	2016-2025	+	+				
				9	10	7	9	1	0

2016 онд Засгийн газрын тогтоолоор баталсан үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх 9 хөтөлбөр, 2017 онд 10 хөтөлбөр, 1 стратеги хэрэгжиж байна./Хүснэгт №2-т/

Аудитаар үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр байгаа эсэхийг тодруулж шалгахад 2016 онд хэрэгжсэн “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хоёр дахь хөтөлбөрийг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр болон, орон нутагтаа хэрэгжүүлэх төлөвлөгөөг Аймгийн Засаг даргын 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/550 дугаар захирамжаар батлуулан ажилласан боловч энэ хөтөлбөр нь 2017 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс хүчингүй болж “Халдварт бус өвчинтэй тэмцэх” нэрээр батлагдан үргэлжлэн хэрэгжиж эхэлсэн тул аймгийн баталсан дэд хөтөлбөр, төлөвлөгөө хүчингүй болсон байна.

2016, 2017 онуудад хэрэгжсэн бусад үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр болон орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулж ажиллаагүй байна. /Хүснэгт №2-т/

2013-2016 онд хэрэгжсэн Эрүүл мэндийн сайдын 2016 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 228 тоот тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын хөгжил” хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг ирүүлээгүй болно.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 353 тоот тогтоолоор баталсан 2015-2025 онуудад хэрэгжих “Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлах тухай” 2017 оны 24 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого хэрэгжүүлэх талаар” 2017 оны А/101 тоот тушаалаар орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулах заавар, дэд хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зааврыг тус тус хавсралтаар баталж ирүүлсэн байна. Энэхүү дэд хөтөлбөрийг боловсруулах мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангах зорилгоор Эрүүл мэндийн яамнаас сургалт зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын -20-ны өдрийн А/345 тоот захирамжаар 2017-2021 онд хэрэгжүүлэх “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан байна.

2.2. Харъяа эрүүл мэндийн салбарын байгууллагууд төсөл хөтөлбөрийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Үндэсний хөтөлбөрүүдийг дараах эх үүсвэрүүдээс санхүүжүүлсэн байна.

- Үндэсний хөтөлбөр болон эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр 1
- Үндэсний хөтөлбөр болон эрүүл мэндийг дэмжих сан, байгууллагын төсөв, буцалтгүй зээл тусламжаас 1
- Улсын төсөв /Хөтөлбөрийн дотоод урсгалын зардал/, НҮБ-ын ХАС, ОУБ-өөс 1,

- ЭМГазар, сум дундын эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн хөтөлбөрийн дотоод урсгалын зардлаас 1
- Улсын болон орон нутгийн төсвөөс 1
- Улс, орон нутгийн төсөв, хандивлагч орон, НҮБ-ын төрөлжсөн болон олон улсын байгууллагын хандив, тусламж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж иргэдийн санаачилгаар хуримтлагдсан тусламж, хандивын хөрөнгөөр 1
- Улсын төсөв, буцалтгүй тусламж хөтөлбөрийн санхүүжилтээр 1 төсөл арга хэмжээ санхүүжигдсэн байна.

2017 онд хэрэгжсэн үндэсний хөтөлбөрүүдээс 3 нь өмнөх онуудаас үргэлжлүүлэн хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр ба бусад төсөл хөтөлбөрүүд дараах эх үүсвэрүүдээс санхүүжигдсэн байна.

- Улсын төсөв, буцалтгүй тусламжаар 4,
- Улсын болон орон нутгийн төсөв, хөтөлбөрийн дотоод урсгалын зардлаар 1
- Улсын төсөв /Хөтөлбөрийн дотоод урсгалын зардал/-өөр 2
- Улсын төсвөөр 3 төсөл арга хэмжээ санхүүжигдсэн байна.

Аймгийн Эрүүл мэндийн салбарын 2016 оны төсөвт төсөл, хөтөлбөрийн зардалд 65,3 сая төгрөг, 2017 онд 57,4 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Үүнээс аймгийн ЭМГ-ын төсөв 2016 онд 17,0 сая төгрөг, 2017 онд 14,6 сая төгрөг байна.

Аймгийн Эрүүл мэндийн газар нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу төсөл, хөтөлбөрийн сургалт, томилолт, хөтөлбөрийн урсгал зардалд зарцуулсан байна.

ЭМГазраас Эрүүл мэндийн харьяа салбар байгууллагуудын төсөл хөтөлбөрийн зардлын тайлан хүлээн авдаггүй, төсөл, хөтөлбөрийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд хяналт тавьж ажиллаагүй байна.

2.3 Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

2016 онд Засгийн газрын тогтоолоор баталсан Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх 9 үндэсний хөтөлбөр хэрэгжсэн ба аудитаар 7 хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан ирүүлсэн байна. “Эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр ба “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг ирүүлээгүй байна.

2016, 2017 онд төсөл хөтөлбөрүүдийг үндсэн хэрэгжүүлэгч байгууллагууд болох ЭМГазар, Нэгдсэн эмнэлэг, Сум дундын эмнэлэг, сум өрхийн эрүүл мэндийн төвүүд, АЗДТГазар, ерөнхий боловсролын сургуулиуд, аймгийн төрийн ба төрийн бус байгууллагууд хамтран хэрэгжүүлсэн байна. 2016 оны төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 60,8 хувьтай, 2017 оны төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 77,4 хувьтай байна.

2016 онд 3 үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд, 2017 онд 5 хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт хийж, үнэлэлт дүгнэлт өгсөн боловч хангалттай үндэслэлтэй нотлох баримтаар дэмжигдээгүй байна.

Үүнээс үзэхэд ЭМГ-ын зүгээс төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Бүлэг 3

Худалдан авах ажиллагааг хэрэгцээ, шаардлагад үндэслэн төлөвлөж, хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

3.Худалдан авах ажиллагааг хэрэгцээ, шаардлагад үндэслэн төлөвлөж, хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

3.1. Эмийн батлагдсан төсөвт зардлын 80 хувиар тооцож, худалдан авах ажиллагааг төлөвлөж ирсэн байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн 2016, 2017 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур бодисыг худалдан авах ажиллагааг хэрэгцээ, шаардлагад үндэслэн үр ашигтай төлөвлөсөн эсэхийг шалгаж дүгнэхэд дараах байдалтай байна.

2016, 2017 онуудад Нэгдсэн эмнэлэг 1, Сум дундын эмнэлэг 3, сум, тосгоны Эрүүл мэндийн төв 11, нийт 15 захиалагчийн эм худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд 2016 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур бодисыг худалдан авах захиалгаа цаасан хэлбэрээр ирүүлсэн байна.

2017 онд нийт захиалагч 15 байгууллагын 13-аас эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур бодисыг худалдан авах захиалга авсан байна.

Алтай, Булган сумын эрүүл мэндийн байгууллагууд эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур бодисыг худалдан авах захиалгаа цахимаар ирүүлсэн байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгээс бусад захиалагч байгууллагуудын ирүүлсэн захиалгыг багц бүрээр дүгнэж тухайн байгууллагын дарга, нягтлан бодогч болон холбогдох эмийн мэргэжилтнээр хянуулж гарын үсэг зуруулж, тамга тэмдэг дарж, хянаж баталгаажуулж аваагүй байна.

Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур бодисыг худалдан авах захиалгыг аймгийн дүнгээр нэгтгэл хийж, хянаж баталгаажуулах ажил хангалтгүй байна.

Ирүүлсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур бодисыг худалдан авах захиалгыг хэрэгцээ, шаардлагадаа үндэслэн төлөвлөсөн эсэхийг аймгийн ЭМГазар хянаж, баталгаажуулах, баримтжуулах ажил хангалтгүй байна.

Захиалга ирүүлсэн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур бодис худалдан авах захиалгыг нэгтгэхэд:

Хүснэт №3

сая төгрөгөөр

Эрүүл мэндийн байгууллагууд	2016 он			2017 он		
	Эмийн батлагдсан төсөв	Эмийн захиалга	Хувь	Эмийн батлагдсан төсөв	Эмийн захиалга	Хувь
Нэгдсэн эмнэлэг	1004.2	752.6	74.9	1086.3	877.5	80.8
Дэлүүн сумын СДЭ	31.9	24.9	78.1	31.6	28.2	89.2
Ногооннуур сумын СДЭ	31.7	22.3	70.3	31.4	27.4	87.3
Цэнгэл сумын СДЭ	35.6	27.3	76.7	35.2	31.7	90.1
Сумдын Эрүүл мэндийн төвүүд	195.3	154.2	79.0	190.9	165.4	86.6
	1298.7	981.3	75.8	1375.4	1130.2	86.8

Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер зарлахад нийт төсөвт өртгийн 80-90%-д багтааж зарласан байна.

Аймгийн эрүүл мэндийн салбарын эмийн батлагдсан төсөв 2016 онд 1298,7 сая төгрөг, 2017 онд 1375,4 сая төгрөг байна. 2016 онд нийт төсөвт өртгийн 76%-аар, 2018 онд 86,9 %-аар худалдан авах ажиллагаагаа төлөвлөж, тендер зарласан байна. /Хүснэгт №3/

3.2 Худалдан авах ажиллагааг зохих хууль журмын зохион байгуулсан байна.

Аймгийн ЭМГ-ын даргын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/67 тоот тушаалаар Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн 2016 онд хэрэглэх, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур бодис нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй, 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/45 тоот тушаалаар 2017 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур бодис нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулсан байна.

Үнэлгээний хорооны даргаар ЭМГ-ын хэлтсийн даргыг томилж, гишүүдээр ЭМГ-ын эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан мэргэжилтэн, ЭМГ-ын нягтлан бодогч нарыг болон Нэгдсэн эмнэлгийн дарга, орлогч дарга, нягтлан бодогч, Нэгдсэн эмнэлгийн эм зүйч нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

2016, 2017 онд үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй байна.

ЭМГ-ын дарга 2016, 2017 онуудад аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур бодис нийлүүлэх тендерийн багц, үнэлгээний хорооны гишүүдийн ажил үүргийн хуваарийг баталсан байна.

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүн, түүнд тавигдах үндсэн дөрвөн шаардлагыг хангасан эсэх талаар шалгахад дараах нийтлэг зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Үнэлгээний хорооны гишүүдийн 3 гишүүн АЗ сертификатгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 47.6-д заасны дагуу үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна гэсэн шаардлагыг хангаагүй байна.
- Үнэлгээний хорооны бүрэлдэхүүн болох 7 хүн нь аймгийн ЭМГ-ын болон аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга, ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн төлөөлөл ороогүй байгаа нь хуулийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна” гэсэн шаардлагыг хангаагүй байна.
- Үнэлгээний хорооны гишүүд нь үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг болон ашиг сонирхлын зөрчилгүй болох талаар мэдүүлгийг гаргаж өгөөгүй байна.

Үнэлгээний хорооны гишүүд баталсан ажил үүргийн хуваарийг баримталж ажилласан байна.

2016 онд Эрүүл мэндийн газраас харьяа байгууллагуудын хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурыг ханган нийлүүлэгчийг сонгон шалгаруулах эмийн тендерийг нийт 23 багцаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалт зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Тендерийг 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдөр зарлаж 2016 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр нээсэн байна. Тендерт нийт 17 байгууллага санал ирүүлж оролцсон ба үүнээс 18 багцад 8 байгууллагын ирүүлсэн саналыг шалгаруулсан байна. Тендер шалгаруулалттай холбоотой ямар нэгэн гомдол гараагүй байна

Гүйцэтгэлээр 2016 онд аймгийн Эрүүл мэндийн салбарын харьяа байгууллагууд 1371,2 сая төгрөгийн эмийн худалдан авалт хийсэн тайлан ирүүлжээ.

2017 онд Эрүүл мэндийн газраас харьяа байгууллагуудын хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурыг ханган нийлүүлэгчийг сонгон шалгаруулах эмийн тендерийг нийт 22 багцаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтаар зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

2017 онд Үнэлгээний хорооны гишүүд 3 удаа хуралдсан ба 1 дүгээр сарын 20-ны өдрийн 3 дахь хурлын тэмдэглэлд үнэлгээний хорооны нарийн бичгээс бусад үнэлгээний хорооны дарга болон гишүүд гарын үсэг зураагүй буюу хүчин төгөлдөр бус байна.

Тендер шалгаруулалтын материалыг шалгахад тендерт санал ирүүлсэн компаниуд нь олон жилийн туршлагатай, тендерт жил бүр оролцож байсан компаниуд байна.

Тендерт оролцсон компаниудыг тодорхой шалгуур, үзүүлэлт бүрээр үнэлгээ хийснээс гадна ТБОНӨХБАҮХАТХуулийн 28.7.5-д "эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад чанар ба үнэлгээний харьцуулалтаар өндөр оноо бүхий тендерийг "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер гэж үзнэ", 28.3-д "Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна" гэсэн заалтыг баримталж ажилласан байна. Шалгарсан компаниудтай гэрээ хийж, хэрэгжилт, үр дүнг тооцож ажилласан байна.

Үнэлгээний хорооны сонгон шалгаруулалтын дүнг үндэслэж аймгийн ЭМГ-ын даргын албан тоотоор гэрээ байгуулах эрх олгосон байна. Тендерт шалгарсан компаниудтай аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сум дундын эмнэлэг, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга болон аймгийн ЭМГ-ын эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан мэргэжилтэн нар гарын үсэг зурж гэрээ байгуулж, аймгийн ЭМГ-ын дарга гэрээг баталсан байна.

Эмийн худалдан авалтын тайланг, гэрээний үнэтэй тулгахад дараах байдалтай байна./Эх сурвалж: ЭМГазраас ирүүлсэн гэрээний эх хувь, эмийн худалдан авалтын тайлан/

Хүснэгт №4

2016 он

Гэрээний үнэ	Гүйцэтгэл	Зөрүү	
		илүү	дутуу
1044.866	1371.2	349.4	23.1

2017 он

Гэрээний үнэ	Гүйцэтгэл	Зөрүү	
		илүү	дутуу
1259.6	1357.6	148.7	50.7

Эмийн төсөвт өртгийн 80-90%-д тендер зарлаж, шалгаруулалт хийгддэг ба тухайн жилийн өвчлөлийн байдлаас шалтгаалан хэрэглэгч байгууллагаас захиалгын тоонд өөрчлөлт оруулах шаардлага гарвал эм, эмнэлгийн хэрэгслийг гэрээнд заасан үнээр нийлүүлж авдагтай холбоотой гүйцэтгэлээр илүү байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1-р бүлэг.

Батлагдсан орон тооны хязгаарыг хэтрүүлж ажилласан байна.

1. Эрүүл мэнд, спортын яамнаас баталсан орон тооны хязгаараас хэтрүүлж орон тоогоо баталж ажилласан байна.
2. Төлөвлөгөөт үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна.
3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
4. Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлсэн байна.
5. Төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хариуцсан нэгж, ажилтан байхгүй байна.

2-р бүлэг

2016 оны төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 60,8 хувьтай, 2017 оны төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 77,4 хувьтай байна.

1. Төрөөс хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.
2. Эрүүл мэндийн салбарын байгууллагууд төсөл хөтөлбөрийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд хяналт тавьж ажиллаагүй байна.
3. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

3-р бүлэг.

Худалдан авах ажиллагааг хэрэгцээ, шаардлагад үндэслэн төлөвлөж, хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

1. Эмийн батлагдсан төсөвт зардлын 80 хувиар тооцож, худалдан авах ажиллагааг төлөвлөж ирсэн байна.
2. Худалдан авах ажиллагааг зохих хууль журмын зохион байгуулсан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Эрүүл мэндийн газрын дарга С.Айгүл-д:

1. Хуулийн зөвлөх нэртэй хууль бусаар ажиллуулж байгаа байнгын орон тоонд эрүүл мэндийн салбарын дотоод хяналт, хууль эрх зүйг хариуцан мэргэжилтэн авч ажиллуулах нь зүйтэй.
2. Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа үндэсний 10 хөтөлбөр, 1 стратегийг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулах арга хэмжээ авч ажиллах;

Зөвлөмжийн хариуг 2019 оны 4 дүгээр сарын 05-ны дотор ирүүлнэ үү.

Байгууллагын санал

Эрүүл мэндийн газраас ирүүлсэн санал

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**

83127, Өлгий-Баян-Өлгий аймаг,
Утас/факс: 704225311
hsic_baynolgiy.gov.mn
www.health.baynolgiy.gov.mn

2018.07.09 № 521

төвий 2018.07.09 оны № 213 -т

**Г БЯАН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Манай байгууллагын 2016, 2017 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын тайланд тусгагдсан албан шаардлага, зөвлөмжийг цаашид үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллах болно.

ДАРГА

[Signature]
Бичигч

С.АЙГУЯ

0000000521

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:

Дарга, тэргүүлэх аудитор

М.Хуанган

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

Аудитын менежер

Х.Женисбек

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН :

Ахлах аудитор

Д.Назгүл

Аудитор

Р.Баярмаа